



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/266

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "Б" заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 20, 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн зөвлөгөөний шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган газар тариалангийн үрийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор авсан тарималын болон малын тэжээлийн үрийн үнэ 4,375,000 төгрөгийг 1 дүгээр хавсралтаар, үр ачиж ирсэн тээврийн хөлсний зардал 5,400,000 төгрөгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Газар тариалангийн таримал болон тэжээлийн ургамлын үрийн үнэ, тээврийн зардалд 9,775,000 төгрөг /Есөн сая долоон зуун далан таван мянган/ -ийг "Газар тариалан" хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний зардлаас гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газрын дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02/201912
D/Zax-A/266-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 03-ны өдрийн
А/266 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТООС АВЧ ИРСЭН ХҮЛЭМЖ, ТАРИМЛЫН ҮРИЙН ҮНЭ

д/д	Таримлын нэр	Сортын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тайлбар
1	Төмс	Гала	тн	20		-	
2	Сармис		кг	20	20,000	400,000	
3	Хүрэн манжин	Бордоо 237	кг	5	23,000	115,000	
4	Улаанбуудай	Алтайская 325	тн	2	720,000	1,440,000	
5	Овьёос		тн	2	600,000	1,200,000	
6	Бөөрөнхий байцаа /эрт/	№1 Грибовский 147	кг	4	90,000	360,000	
7	Бөөрөнхий байцаа /дундын/	455-2018	кг	6	80,000	480,000	
8	Улаан лооль	Сибирский скороспелый	кг	2	40,000	80,000	
9	Вандуй		кг	100	2,000	200,000	
10	Шар буурцаг		кг	50	2,000	100,000	
Дүн			кг	24,187		4,375,000	

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар
сарын 03-ны өдрийн А/266 дугаар
захирамжийн хавсралт

ХҮЛЭМЖ, ТАРИМЛЫН ҮРИЙН ТЭЭВРИЙН ХӨЛС

Д/Д	Материалын үнэт зүйлийн нэр	Хэмжээ м2	Хэмжих нэгж	Тоо	Тээврийн хөлс	
					Нэг кг ачааны үнэ /төг/	Нийт дүн
1	Төмс, улаан буудай, овъёосны үр		кг	24000	220	5,280,000
2	Дарханаас Вандуй, шар буурцаг тээвэрлэж ирсэн зардал		кг	150	800	120,000
	Нийт					5.400,000

--oOo--